**ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хөвсгөл аймгийн Цагаан-үүр сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2025/015/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Мөрөн сум<br>2024 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn<br>Аудитор: Б. Ариунтуяа<br>Утас:99036832 Цахим хаяг: Ariuntuya@audit.gov.mn<br>Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа<br>Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com<br>Аудитор Ц.Мөнхтуяа<br>Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 57120
Утас/факс:7038 3793. Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/180

танай ______________-ны № ______________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-ҮҮР СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.УУГАНЦЭЦЭГ ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,055,369.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас гүйцэтгэлээр 930,948.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, үлдэгдэл 124.421.8 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хамээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 50,384.4 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчлийг илрүүлснээс аудитын хугацаанд 44,057.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 6,326.5 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж, нийцлийн аудиттай холбоотой зөрчилд 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 85.0 хувьтай дүгнэсэн байна.

6700001/28

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АЛБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **169,524,392.30** | **275,591,634.28** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 18,806.50 | 00.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 18,806.50 | 00.00 |
| **3121** | **Төгрөг** | 18,806.50 | 00.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 18,806.50 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 24,490,148.00 | 124,886,569.51 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 464,793.56 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 24,490,148.00 | 124,421,775.95 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 145,015,437.80 | 150,705,064.77 |
| **351** | **Түүхий эд материал** | 49,311,733.78 | 51,407,095.69 |
| 35130 | Эм боох материал | 49,311,733.78 | 51,407,095.69 |
| **354** | **Хангамжийн материал** | 95,703,704.02 | 99,297,969.08 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 425,000.00 | 115,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 89,000.00 | 52,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 14,187,046.04 | 13,401,185.70 |
| 35460 | Хүнсний материал | 1,475,515.00 | 2,164,415.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 79,527,142.98 | 83,564,868.38 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **350,183,849.19** | **365,921,351.81** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 350,183,849.19 | 365,921,351.81 |
| **392** | **Биет хөрөнгө** | 333,707,849.19 | 349,445,351.81 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 216,015,094.58 | 216,015,094.58 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -97,524,215.21 | -116,816,539.37 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 76,016,000.00 | 116,151,714.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -55,116,861.26 | -36,240,004.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 237,058,525.42 | 254,826,070.42 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -80,032,113.91 | -115,456,689.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,966,000.00 | 23,966,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -7,398,333.37 | -10,493,950.48 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 35,949,727.30 | 35,949,727.30 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -15,225,974.36 | -18,456,071.60 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 16,476,000.00 | 16,476,000.00 |
| 39301 | Програм хангамж | 781,470.00 | 781,470.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -781,470.00 | -781,470.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,476,000.00 | 16,476,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **519,708,241.49** | **641,512,986.09** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **12,057,572.70** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 12,057,572.70 |

| | | | |
|---|---|---|---|
| **413** | **Өглөг** | 00.00 | 12,057,572.70 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 11,661,968.19 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 395,604.51 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 395,604.51 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **519708241.49** | **629455413.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 519,708,241.49 | 629,455,413.39 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 416,783,360.00 | 416,783,360.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 416,783,360.00 | 416,783,360.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -65,485,375.27 | 44,261,796.63 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -65,485,375.27 | -65,485,375.27 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 109,747,171.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 168,410,256.76 | 168,410,256.76 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **519,708,241.49** | **641,512,986.09** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **775,692,375.35** | **1,238,958,768.29** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **91,715,004.35** | **114,969,011.54** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 91,715,004.35 | 114,969,011.54 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 91,715,004.35 | 114,969,011.54 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 91,715,004.35 | 114,969,011.54 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **683,977,371.00** | **1,123,989,756.75** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 47,150,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 47,150,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,610,600.00 | 45,960,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,610,600.00 | 45,960,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 651,366,771.00 | 1,030,879,756.75 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 651,366,771.00 | 1,030,879,756.75 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **768,822,683.15** | **1,119,736,596.45** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **768,822,683.15** | **1,119,736,596.45** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 768,822,683.15 | 1,074,586,596.45 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 476,464,907.00 | 703,355,469.44 |
| 210101 | Үндсэн цалин | 317,129,539.00 | 453,624,024.44 |
| 210102 | Нэмэгдэл | 96,707,698.00 | 207,134,145.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,825,000.00 | 18,228,000.00 |
| 210104 | Урамшуулал | 56,802,670.00 | 24,369,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 60,060,540.00 | 79,382,176.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,060,518.44 | 51,400,523.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,830,649.10 | 6,994,522.80 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,860,119.27 | 5,928,634.74 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 937,203.26 | 3,296,800.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,372,049.93 | 11,761,695.26 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,061,677.96 | 36,745,860.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,143,133.96 | 4,434,114.30 |
| 210302 | Түлш, халаалт | 14,358,544.00 | 32,188,246.04 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 560,000.00 | 123,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,398,588.00 | 34,644,895.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,410,400.00 | 1,488,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,664,690.00 | 25,969,945.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,639,998.00 | 2,640,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,683,500.00 | 4,546,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 87,940,454.18 | 99,746,940.23 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 72,697,689.18 | 86,065,490.23 |
| 210502 | Хоол, хүнс | 15,242,765.00 | 13,681,450.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,000,000.00 | 21,745,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,000,000.00 | 21,745,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,806,000.00 | 2,596,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,806,000.00 | 2,596,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,973,950.00 | 20,767,149.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,425,000.00 | 19,095,799.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,322,000.00 | 1,152,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 133,950.00 | 163,350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 122,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 11,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 164,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 60,000.00 | 58,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 74,116,566.01 | 75,602,306.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,981,300.00 | 5,011,550.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 68,135,266.01 | 70,590,756.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 00.00 | 45,150,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 45,150,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 45,150,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **6,869,692.20** | **119,222,171.84** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 9,474,999.94 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 9,474,999.94 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -9,474,999.94 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **6,869,692.20** | **109,747,171.90** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **659,487,223.00** | **1,024,058,128.80** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **659,487,223.00** | **1,024,058,128.80** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 47,150,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 47,150,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,610,600.00 | 45,960,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,610,600.00 | 45,960,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 626,876,623.00 | 930,948,128.80 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 626,876,623.00 | 930,948,128.80 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **675,481,276.50** | **1,022,492,450.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **675,481,276.50** | **1,022,492,450.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **675,481,276.50** | **977,342,450.30** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 476,465,505.00 | 703,810,263.00 |
| 210101 | Үндсэн цалин | 330,679,299.00 | 435,218,942.00 |
| 210102 | Нэмэгдэл | 93,404,902.00 | 229,228,318.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,653,000.00 | 17,634,900.00 |
| 210104 | Урамшуулал | 46,728,304.00 | 21,728,103.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 60,059,942.00 | 79,392,176.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,060,515.44 | 55,724,059.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,830,649.10 | 5,845,304.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,860,116.27 | 4,138,228.26 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 937,202.26 | 2,699,592.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,371,458.93 | 10,984,990.54 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,610,600.00 | 35,960,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,143,133.96 | 4,434,114.30 |
| 210302 | Түлш, халаалт | 25,907,466.04 | 31,402,385.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 560,000.00 | 123,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,064,688.00 | 34,216,295.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,730,000.00 | 1,067,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,944,690.00 | 25,969,945.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,639,998.00 | 2,640,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,750,000.00 | 4,539,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 51,643,791.50 | 71,148,721.81 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 36,604,791.50 | 56,778,371.81 |
| 210502 | Хоол, хүнс | 9,039,000.00 | 14,370,350.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,000,000.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,500,000.00 | 24,753,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,500,000.00 | 24,753,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,806,000.00 | 2,596,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,806,000.00 | 2,596,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,685,450.00 | 20,767,149.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,425,000.00 | 19,095,799.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,322,000.00 | 1,152,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 133,950.00 | 163,350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 122,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 11,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 164,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 771,500.00 | 58,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,645,300.00 | 4,698,045.49 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,645,300.00 | 4,698,045.49 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **45,150,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 45,150,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 45,150,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-15,994,053.50** | **1,565,678.50** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **17,256,000.00** | **1,584,485.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **17,256,000.00** | **1,584,485.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 17,256,000.00 | 1,584,485.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 17,256,000.00 | 1,584,485.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-17,256,000.00** | **-1,584,485.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -33,250,053.50 | -18,806.50 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 33,268,860.00 | 18,806.50 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 18,806.50 | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 400,307,360.00 | 11,036,542.70 | -145,831,231.87 | 265,512,670.83 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 2,944,200.00 | 2,944,200.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 400,307,360.00 | 11,036,542.70 | -142,887,031.87 | 268,456,870.83 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | -2,944,200.00 | | -2,944,200.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -11,137,091.30 | -11,137,091.30 |
| D01 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 416,783,360.00 | 168,410,256.76 | -65,485,375.27 | 519,708,241.49 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 416,783,360.00 | 168,410,256.76 | -65,485,375.27 | 519,708,241.49 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 109,747,171.90 | 109,747,171.90 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **416,783,360.00** | **168,410,256.76** | **44,261,796.63** | 629,455,413.39 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Улсын төсвийн гүйцэтгэл:**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,132,927,600.00 | 978,116,935.30 | 86.34 | 154,810,664.70 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,132,927,600.00 | 978,116,935.30 | 86.34 | 154,810,664.70 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,013,237,600.00 | 932,966,935.30 | 92.08 | 80,270,664.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 748,324,600.00 | 703,810,263.00 | 94.05 | 44,514,337.00 |
| 210101 | Үндсэн цалин | 450,658,600.00 | 435,218,942.00 | 96.57 | 15,439,658.00 |
| 210102 | Нэмэгдэл | 258,279,300.00 | 229,228,318.00 | 88.75 | 29,050,982.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,450,000.00 | 17,634,900.00 | 186.61 | -8,184,900.00 |
| 210104 | Урамшуулал | 29,936,700.00 | 21,728,103.00 | 72.58 | 8,208,597.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 81,633,900.00 | 79,392,176.00 | 97.25 | 2,241,724.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 55,737,700.00 | 55,724,059.98 | 99.98 | 13,640.02 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,474,000.00 | 5,845,304.27 | 90.29 | 628,695.73 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,237,000.00 | 4,138,228.26 | 127.84 | -901,228.26 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,237,000.00 | 2,699,592.95 | 83.40 | 537,407.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,948,200.00 | 10,984,990.54 | 84.84 | 1,963,209.46 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,129,600.00 | 34,216,295.00 | 85.26 | 5,913,305.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,352,600.00 | 1,067,250.00 | 24.52 | 3,285,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,221,800.00 | 25,969,945.00 | 92.02 | 2,251,855.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,016,100.00 | 2,640,000.00 | 87.53 | 376,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,539,100.00 | 4,539,100.00 | 100.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 91,463,300.00 | 71,148,721.81 | 77.79 | 20,314,578.19 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 72,834,800.00 | 56,778,371.81 | 77.96 | 16,056,428.19 |
| 210502 | Хоол, хүнс | 18,628,500.00 | 14,370,350.00 | 77.14 | 4,258,150.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,500,000.00 | 14,753,000.00 | 84.30 | 2,747,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.00 | 00.00 | 0.00 | 2,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,000,000.00 | 14,753,000.00 | 98.35 | 247,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,000,000.00 | 2,596,800.00 | 86.56 | 403,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,000,000.00 | 2,596,800.00 | 86.56 | 403,200.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 23,296,800.00 | 20,767,149.00 | 89.14 | 2,529,651.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,677,300.00 | 19,095,799.00 | 92.35 | 1,581,501.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 1,152,000.00 | 100.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 354,000.00 | 163,350.00 | 46.14 | 190,650.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 125,000.00 | 122,900.00 | 98.32 | 2,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 29,500.00 | 11,100.00 | 37.63 | 18,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 164,000.00 | 164,000.00 | 100.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 795,000.00 | 58,000.00 | 7.30 | 737,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,889,400.00 | 6,282,530.49 | 79.63 | 1,606,869.51 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,889,400.00 | 6,282,530.49 | 79.63 | 1,606,869.51 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 119,690,000.00 | 45,150,000.00 | 37.72 | 74,540,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 119,690,000.00 | 45,150,000.00 | 37.72 | 74,540,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 119,690,000.00 | 45,150,000.00 | 37.72 | 74,540,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,132,927,600.00** | **978,098,128.80** | **86.33** | **154,829,471.20** |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,011,237,600.00 | 930,948,128.80 | 92.06 | 80,289,471.20 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,011,237,600.00 | 930,948,128.80 | 92.06 | 80,289,471.20 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 121,690,000.00 | 47,150,000.00 | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 18,806.50 | | -18,806.50 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 | | 00.00 |

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **45,960,000.00** | **45,960,000.00** | **100.0** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 45,960,000.00 | 45,960,000.00 | 100.0 | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 45,960,000.00 | 45,960,000.00 | 100.0 | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **35,960,000.00** | **35,960,000.00** | **100.0** | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,000,000.00 | 4,434,114.30 | 73.90 | 1,565,885.70 |
| 210302 | Түлш, халаалт | 29,360,000.00 | 31,402,385.70 | 106.96 | -2,042,385.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 600,000.00 | 123,500.00 | 20.58 | 476,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,000,000.00** | **10,000,000.00** | **100.0** | |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 10,000,000.00 | **100.0** | |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **51,403,400.00** | **45,960,000.00** | **100.0** | |
| **32** | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 51,403,400.00 | 45,960,000.00 | 100.0 | |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 51,403,400.00 | 45,960,000.00 | 100.0 | - |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 50,384.4 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчлийг илрүүлснээс аудитын хугацаанд 44,057.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 6,326.5 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж, нийцлийн аудиттай холбоотой зөрчилд 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

**Залруулсан алдаа**

- Үндсэн болон нэмэгдэл цалин, байгууллагаас төлөх НДШ-ийн 43,967.9 мянган төгрөгийг мөнгөн зарлагын журналд и-хуулгатай зөрүүлсэн ба зориулалт арга хэмжээний зардалд бүртгээгүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт "үнэн зөв байх;" заалтад нийцэхгүй "ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул холбогдох дансдад бүртгэж залруулсан.
- Нэгдсэн эмнэлгээс 90.0 мянган төгрөгөөр худалдан авсан хүчилтөрөгчийн шингэнийг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зарлагдсан зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх;"заалтад нийцэхгүй " Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй тул тооцооны дансанд орлого авч залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 6,326.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 12,299.3 мянган төгрөгөөс 5,972.8 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

- Бараа материалын үлдэгдэлд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 7,867.2 мянган төгрөгийн вакцин, эмийн үлдэгдэл байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэв.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавconfigart нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

2. **Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал**

*Илрүүлэлт:*

Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас 2024 онд 1,052,654.2 мянган төгрөгийг нэхэмжилснээс 21,774.4 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;", Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоолын 3.1 "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны програм, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,.." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

3. **Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Хишигт макс ХХК-аас худалдан авсан аж ахуйн материалын үнийг хоол, хүнсний зардлаас зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай" заавартай нийцэхгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж ажиллах

4. **Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар**

*Илрүүлэлт:*

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзэхгүй, Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэж урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан "Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.1 заалтад "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;" мөнгөн урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

**5. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Тус эрүүл мэндийн төв www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 31, зарлагын 10 гүйлгээг хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 25 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 заалт "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;", 6.4.5 заалт "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.8 заалт "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**6. Ахмадын сангийн талаар**

*Илрүүлэлт:*

Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах…” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

Дээрх албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 1. Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл.

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн болон нэмэгдэл цалин, байгууллагаас төлөх НДШ-ийн 43,967.9 мянган төгрөгийг мөнгөн зарлагын журналд и-хуулгатай зөрүүлж, зориулалт арга хэмжээний зардалд бүртгээгүй | 1 | 43,967.9 | | | 1 | 43,967.9 | 1 | 43,967.9 | | |
| Нэгдсэн эмнэлгээс худалдан авсан хүчилтөрөгчийн шингэнийг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зарлагдсан | 1 | 90.0 | | | 1 | 90.0 | 1 | 90.0 | | |
| Дүн | 2 | 44,057.9 | | | 2 | 44,057.9 | **2** | 44,057.9 | | |

### 2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шинээр мөрдөгдөж эхэлсэн хууль, тогтоомжийн өөрчлөлтүүдийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгаагүй | 1 | 0,0 | | | | | 1 | 0,0 |
| Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзэхгүй, Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэж урамшуулсан | 1 | 5,884.0 | | | | | 1 | 5,884.0 |
| Хишигт макс ХХК-аас худалдан авсан аж ахуйн материалын үнийг хоол, хүнсний зардлаас зарцуулсан | 1 | 442.5 | | | | | 1 | 442.5 |
| Дүн | 3 | 6,326.5 | | | | | 3 | 6,326.5 |

### 1. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 31, зарлагын 10 гүйлгээг хугацаа хоцроосон, төсөв, өмч, | 1 | 0 | | | | | 1 | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 25 шийдвэрийг мэдээлээгүй | | | | | | | | |
| Бараа материалын дансанд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн эм, ковид 19-ын вакцины үлдэгдэл | 1 | 0,0 | | | 1 | 0,0 | | |
| Ахмад настны тухай" хуулийн 14.7 дахь заалтыг хэрэгжүүлээгүй ахмадын сан байгуулж данс нээгээгүй | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системээр үнэн зөв, бүрэн тайлагнаж чадаагүйгээс ЭМДС-аас санхүүжилтийг бүрэн авч чадаагүй, | 1 | 0,0 | | | | | 1 | 0,0 |
| Дүн | 4 | 0,0 | | | 1 | 0,0 | 3 | 0,0 |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр    № 39/A822704691/ ХӨА-2025/015/НА-СТА-ТШЗ    Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын үлдэгдлийг эхэлж авснаа эхэлж зарлагадах аргаар зарлагадаагүй, эмчилгээнд хэрэглэх шаардлага гараагүй, эмийн үлдэгдэлд тавих дотоод хяналт сул зэрэг шалтгаанаар тус байгууллагын бараа материалын дансны үлдэгдэлд 7,867,200 (Долоон сая найман зуун жаран долоон мянга хоёр зуу) төгрөгийн өмнөх оноос шилжиж ирсэн, бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй эм бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно*" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материалыг үр ашиггүй удаан хадгалахгүй байх, эмийн үлдэгдэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, бараа материалын үлдэгдлийн эхэлж авснаа эхэлж зарлагадах аргыг тууштай мөрдөж ажиллах, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаан-Үүр сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Уuganцэцэг, нягтлан бодогч Б.Золжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: [signature] Л.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР [signature] Г.ИЧИНХОРЛОО

6724000523